



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨВ АЙМАГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний Төв аймаг дахь салбар зөвлөл Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр “Ардын цагдаа” сэдвийн хүрээнд Төв аймгийн зарим сум багийн хэсгийн төлөөлөгч, байцаагчдын ажлаа тайлагнах үйл явцад мониторинг хийлээ. Тус мониторингийн хүрээнд Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Лүн сумдын хэсгийн төлөөлөгч, Зуунмод сумын 6 багийн хэсгийн байцаагчдын ажлын тайлан тавих ажиллагааны үр дүн, чанар, хүртээмж, иргэдээс гарсан санал, шүүмжийн мөрөөр хийсэн ажлын үр дүнг үнэлэхийн зэрэгцээ энэ талаарх иргэдийн мэдлэгийг сайжруулахыг зорьсон.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН ДҮН

- Цагдаагийн байгууллага олон нийтэд үйл ажиллагааны тайлангаа танилцуулах явцыг ажиглахад Зуунмод сумын 1, 3-р баг, Борнуур сумаас бусад нь нэр төдий хандсан, үйл ажиллагааны тайлангаа иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр танилцуулаагүй, хурлаас гарсан саналд ажил хэрэгч хандаагүй, хурлын тэмдэглэлийг бүртгэлд аваагүй зэрэг дутагдал ажиглагдлаа.
 - Зуунмод сумын 6 багийн хэсгийн байцаагчдын ажлын тайланг аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулан багийн Иргэдийн нийтийн хурал дээр танилцуулсан бөгөөд энэ үйл явцад шинжилгээ хийхэд Номт, Баянхошуу багийн хувьд ажлын тайлангаа ойлгомжтой, тодорхой танилцуулж, гарсан санал дүгнэлтээ баримтжуулсан бол бусад 4 багийн тухайд хурлын тэмдэглэлээ өөрсөд дээрээ аваагүй, зарим нь тэмдэглэл байхгүй, зөвхөн зургаар баримтжуулсан, мэдээллээ танилцуулахдаа гэмт хэргийн өсөлт бууралтын график голдуу харуулж ёс төдий тайлан тавьсан байна. Тус багийн иргэдээс санал асуулга авахад оролцогчдын 40,3 хувь нь ажлын тайлан тавьдгийг мэдэхгүй, 24,6 хувь нь тайлан тавьдаггүй гэж хариулав.
 - Баянчандмань сумын хувьд тайлангаа багийн ИНХ, өдөрлөг, уулзалтын үеэр танилцуулдаг боловч хурлын тэмдэглэлгүй байв. Борнуур сумын хувьд 4 багийн иргэдийн төлөөллийг оролцуулан, ирц оролцоо сайтайгаар тайлангийн хурлыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд санал шүүмж өрнөхийн зэрэгцээ тайлангийн хурлын үр нөлөө, иргэдийн оролцоо дээшилсэн байна. Батсүмбэр сумын тухайд тайлангаа багийн ИНХ-д тавьдаг, хурлын тэмдэглэлтэй байв. Лүн сум 4 багийн ИНХ дээр тайлангаа тавьсан бөгөөд хурлын тэмдэглэл багийн хэсгийн төлөөлөгчид байхгүй байна.

- Мониторингд хамрагдсан ихэнх цагдаагийн алба хаагчид тайлангийн хурлаас гарсан санал, шүүмжид анхаарал хандуулдаггүй, мөрөөр нь ажил зохиодоггүй байдал ажиглагдлаа.
 - Тайлангийн хурлын мөрөөр Зуунмод сумын Номт, Баянхошуу багийн хэсгийн байцаагч нар тайлангийн хурал дээр гарсан асуудлаар ажлын төлөвлөгөө гаргаж, энэ хүрээнд байгууллагуудыг камержуулах, орон байр, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөршийн холбоог сэргээх, туслах малчнаар баталгаатай хүн авах, сэжиг бүхий этгээдийн талаар мэдээлэх утас тараах, малчдын холбоог ажиллуулах зэрэг саналын дагуу тодорхой ажил зохион байгуулсан байна.
 - Борнуур сумын хэсгийн төлөөлөгч хэлэлцүүлгийн мөрөөр олон нийтийн цагдаа, замын цагдаатай болох хүсэлтийг аймгийн цагдаагийн газарт хүргүүлж, оройн цагаар дэлгүүр орчмоор мөнгө нэхдэг хүмүүст арга хэмжээ авах, эзэнгүй нохдыг устгах, тоглоомын газраар явдаг хүүхдүүдийн талаар холбогдох хүмүүст мэдээлж зогсоох, хөдөө малчдаар явах зэрэг саналын дагуу ажил зохиож, иргэдэд хариу мэдэгдсэн байна.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулах зорилгоор бүх сумдад “Нээлттэй өдөр”, Батсүмбэр суманд аймгийн Цагдаагийн газар, ЦЕГ-ын олон нийтийн төвтэй хамтран цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 8000 гаруй гарын авлага тарааж, 1500 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулжээ.

ЗӨВЛӨМЖ

- Хууль зүйн сайдын 2014 оны А/89 тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн тайлан тавих журам” хэрэгжүүлэх талаар гарын авлага, сургалтын хөтөлбөр боловсруулж, алба хаагчдыг сургалтад хамруулах;
- Тайлангийн хурлын үеэр иргэдээс гарсан санал шүүмжийг нэгтгэн, мөрөөр нь ажил зохиож, гарсан үр дүнгийн талаар иргэдэд буцааж мэдээлж хэвших;
- Тайлангийн хуралд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр шинэлэг сонирхолтой ажил төлөвлөн хэрэгжүүлэх.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт НДЭХ-ий Төв аймаг дахь салбараас Цагдаагийн байгууллагын олон нийтэд тайлагнах үйл ажиллагаанд хийсэн мониторингийн үр дүнг хэвлэн нийтлэв. Энэхүү мониторинг нь НДЭХ-ий Төв аймаг дахь салбараас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.